



МОНГОЛ УЛС  
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/25

Эрдэнэбулган сум

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/358 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Р.Гандиймаа/-д даалгасугай.

3. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг сумын түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулахыг Эрүүл мэндийн төвийн дарга нарт, шаардагдах санхүүжилтийг сумын болон сумын эрүүл мэндийн төвийн жил бүрийн төсөвт тусган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай .

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Буяннэмэх/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХНАСАН

000 00102



**“ЭХ, ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ АРХАНГАЙ АЙМАГТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2018-2021 он/**

№	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
<p><b>Зорилт 1.</b> Эх, хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг бусад салбарын бодлогод тусгах замаар эрх зүйн орчныг сайжруулж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжсэнээр эх, хүүхдэд ээлтэй нийгэм эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.</p> <p><b>Зорилт 1-н үр дүн:</b> Эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулна. Нялхсын эндэгдлийг 1000 амьд төрөлтөнд 15 промильд хүргэнэ. Перинаталь эндэгдлийг нийт төрөлтөнд 10 промильд хүргэнэ.</p>					
1.1.1	“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийг байгуулж, ажиллах журмыг батлах	”Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл”-ийн үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрүүл мэндийн газар, Сум, өрхийн ЭМТ	ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ТББ, ОУБ	2018
1.1.2	Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндэд ээлтэй орчин бүрдүүлэх, эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулахад орон нутгийн байгууллагуудын оролцоо, чиг үүргийг тодорхойлж хамтран ажиллах	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн клиникт эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдэнэ.  Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлээс сэргийлэх талаар иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ	Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ	ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, ТББ, Хэвлэл мэдээлэлийн байгууллага	2018-2021
1.1.3	Олон эмэгтэй ажилчидтай байгууллага, аж ахуйн нэгжид хүүхэд саатуулах өдөр өнжүүлэх бүлэг	Үйлчлүүлэгч болон ажилтнууддаа зориулан хүүхэд хөхүүлэх өрөө гаргасан байна.	Эрүүл мэндийн байгууллагууд	Төрийн болон төрийн бус байгууллага	2018-2021

	ажиллуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргаж ээлтэй орчин бүрдүүлэх.				
1.1.4	Эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын ажилчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, суртчилгааг тогтмол хийж хамтран ажиллах	Ухуулга нөлөөллийн уулзалт, сургалт, сурталчилгаа тогтмолжино	Эрүүл мэндийн газар	Цагдаагийн хэлтэс, Онцгой байдал, Эрчим хүч, Ундрага ХХК-ны удирдлагууд	2018-2021
1.1.5	ЕБС, их дээд сургууль, МСҮТөвийн оюутнуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын түвшин, хэрэгцээг тогтоож сургалтын хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэх	Хүүхэд өсвөр үе, залууст нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол дээшилнэ	ЭМГ	ЕБС, МСҮТ, Их дээд сургуулийн удирдлагууд	2018
1.1.6	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх, эмчлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үзүүлэх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар дэшилнэ.	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв, ЗДТГазар	2018
1.1.7	Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, олон улсын байгууллагатай хамтран иргэдийн эсэн мэнд амьдрахуй болон амаржихуйн талаарх хандлага, дадлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, суртчилгааны материал, гарын авлага, олон нийтийн болон нийгмийн харилцааны сувгаар хүргэсэн мэдээлэл сургалт, сурталчилгааны тоо нэмэгднэ	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв, ЗДТГ	2018-2021
1.1.8	Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлс/агаар, ус, хөрсний бохирдол, осол гэмтэл/-г бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах	Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг буурна.	Эрүүл мэндийн газар	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	2018-2021
1.1.9	Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг дэмжигч байгууллага, хамт олныг суртчилах	Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад байгууллагуудын оролцоо нэмэгдэнэ	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	Сумын ЗДТГ-ын НБХэлтэс	2018-2021

Үйл ажиллагааны чиглэл: 1.3 Эх, хүүхдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулахад санхүүгийн нөөцийг дайчлах чиглэлээр						
1.3.1	Аймаг, суманд төрж байгаа эхчүүдийн төрөлтийн нэг удаагийн иж бүрдлийг тухайн орон нутгийн төсвөөс хангах асуудлыг шийдвэрлэх	Эхчүүдэд тусламж сайжирна	үзүүлэх үйлчилгээ	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, Сумын ЭМТ	Аймаг, сумдын ЗДТГ, ОУБ	2019-2021
1.3.2	Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сан байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх	Эх, хүүхдэд яаралтай бэлэн байдал	үзүүлэх тусламжийн хангагдана	ЭМГ	Сумдын ЗДТГ	2018-2021
1.3.3	Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг, Эх, хүүхдэд ээлтэй байгууллага болох хөдөлгөөнийг өрнүүлэн, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах	Болзолт дагуу эх, үзүүлэх сайжирна	уралдааны хүүхдэд үйлчилгээ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ, ЗДТГ, ОУБ	2018-2021
<p><b>Зорилт 2</b> Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүргэнэ.</p> <p><b>Зорилт 2-н үр дүн:</b></p> <p>Жирэмсний эрт хяналтын хувийг 95-д хүргэнэ.</p> <p>Төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын түвшинг 100,000 амьд төрөлтөд 100 хүргэж бууруулна.</p> <p>18-20 долоо хоногтой ургийн бүтцийн эхо шинжилгээний хамрагдалтыг 80 хувьд хүрнэ.</p> <p>НЭҮНШТ-н хэрэгжилтийн хувийг 100-д хүргэнэ.</p>						
Үйл ажиллагааны чиглэл: Эх барих, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношлогоо, эмчилгээний дэвшилтэт аргыг нэвтрүүлж, бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.						
2.1.1	Нөхөн үржихүйн насны, жирэмсэн эхчүүдийн бүртгэлийг сайжруулж, жирэмсний эрт хяналтын ач холбогдлын талаарх мэдээллийг иргэдэд хүргэхэд нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.	Жирэмсэн болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, судалгаатай болж шаардлагатай үйлчилгээг хүргэнэ.		ЭМГ	Сум, өрхийн ЭМТ, ЗДТГ	2018-2021
2.1.2	Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эх, 6-23 сартай хүүхдийг олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл, 5 хүртэлх насны хүүхдийг А, Д амин дэмээр бүрэн хангах	1.Жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхчүүд, 6-23 сартай болон 5 хүртэлх насны хүүхэд амин дэмээр хангагдана.		ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
2.1.3	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд жирэмсэн эхчүүдийг тэмбүү, ХДХВ, хепатитийн В,С вирусын халдвар	Жирэмсэн эхчүүд үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдаж, эрүүл эхээс эрүүл		ЭМГ	Нэгдсэн эмнэлэг,	2018-

	илрүүлэх шинжилгээнд хамруулах	100%	хүүхэд төрөх нөхцөл бүрдэнэ		сумын ЭМТ	2021
2.1.4	Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийг хөх, умайн хавдрын эрт илрүүлэг хамруулах	насны хүзүүний шинжилгээнд	Хөх, умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлж, эмчилнэ. суралчилгаа	ЭМГ	Нэгдсэн эмнэлэг, Сум, өрхийн ЭМТ	2018-2021
2.1.5.	Эмч мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулах.	давтан	Эмчилгээний чанар дээшилнэ			
2.1.6	Малчид, отор нүүдлээр эх, бага насны хүүхдэд мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх.	яваа жирэмсэн явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх.	1.Отроор яваа жирэмсэн эх, хүүхэд үзлэгт хамрагдаж, өвчлөл буурна.	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	Сумын ЭМТ	2018-2021
2.1.7	Багийн эмчийг хүүхдийн яаралтай тусламж мэдээлэл, материалаар хангах.	эх барих, нярай, нэн шаардлагатай болон үзүүлэх цомог, сурталчилгааны	Эх, барих нярайн тусламжийн цомгоор хангагдсана.	ЭМГ	ДЭМБ, ХАС, ОУБ	2018-2021
2.1.8	Гамшиг, онцгой хүүхдэд үзүүлэх мэндийн тусламж, шаардагдах хүний нөөц, эм, хэрэгслийн ажиглах	онцгой байдлын үед үзүүлэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд бэлэн байдлыг хангаж	Яаралтай болон онцгой байдлын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шуурхай байдал хангагдана	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2019
2.1.9	Эх, хүүхэд, мэндийн тусламж, удирдлагын болон дэмжлэг үзүүлж үр дүнг тооцож ажиглах	нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд арга зүйн үнэлгээ хийж	Үйлчилгээний уялдаа холбоо, эмчилгээний чанар дээшилнэ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.2.</b> Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд оношлогоо, эмчилгээний нэвтрүүлэх нэн шаардлагатай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.						
2.2.1	Аймгийн тасгийг төхөөрөмжөөр хангаж, эрүүл мэндийн тусламж сайжруулах	Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн оношилгоо, эмчилгээний тоног	Хүүхдэд үзүүлэх эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2018-2019
2.2.2.	Эмч мэргэжилтнүүдэд зориулсан		Эмч мэргэжилтний ур чадвар			

	эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж, хүүхдийн өвчний цогц менежментийн сургалт зохион байгуулах	дээшилнэ	ЭМГ	Сумын ЭМТ	2018-2021
2.2.3	Нэгдсэн эмнэлэгт хүүхдийн мэс засал, мэдрэлийн болон нярайн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавх бүрдүүлэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	Мэс заслын эмчийг сургаж эмчилгээг эхлүүлнэ	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2018-2021
2.2.4	Сумдын эрүүл мэндийн төвийг шаардлагатай оношилгоо, эмчилгээний багаж хэрэгслээр хангаж, нярай хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний шуурхай байдлыг хангах	Хүүхдийн өвчлөл эндэгдэл буурна	ЭМГ	Сумын ЭМТ	2018-2021
2.2.5	Анхан шатны эрүүл мэндийн төвийг хүүхдийн эмчээр хангаж, архаг өвчтэй хүүхдийн хяналтыг тогтмолжуулах	Анхан шатны эрүүл мэндийн төвийн 70 хувийг хүүхдийн эмчээр хангаж, архаг өвчтэй хүүхдийн хяналтыг сайжруулна.	ЭМГ	Сумын эрүүл мэндийн төв	2018-2019
2.2.6	Дутуу болон бага жинтэй төрсөн нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд "Имж эх" асаргаа, сурфактант эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх	2.Дутуу нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар сайжирна	Нэгдсэн эмнэлэг,	ЭМГ	2018-2020
2.2.7	Эцэг эх, асран хамгаалагчид олон нийтэд суурилсан хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, гэрийн эргэлт, идэвхитэй хяналтын чанар хүртээмжийг сайжруулах	Эцэг, эхийн мэдлэг сайжирч хүүхдийн өвчлөл буурна	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018
2.2.8	Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтэрч байгаа нярайн түнхний дисплази эрт илрүүлэг шинжилгээг хийх	Нярайг түнхний дисплази эрт илрүүлэх шинжилгээнд 100 хувь хамруулна	Нэгдсэн эмнэлэг	ЭМГ	2018-2020

2.2.9	Хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх	Эмчилгээний үр дүн сайжирч өвчлөл буурна	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	ЭМЯ, ОУБ	2018-2019
2.2.10	Цэцэрлэг, сургуулийн сурагчдын товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх	Вакцинд хамрагдвал зохих хүүхдийн хамрагдалтыг 100 хувьд хүргэнэ.	ЭМГ	БСГ, Сум, өрхийн ЭМТ	2018-2021
2.2.11	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангаж, 18-36 сартай хүүхдэд эрүүл мэндийн цогц үзлэг хийж хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх	Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт үед нь илрүүлж, хяналтанд авч эмчилнэ.	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
2.2.12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх кабинет ажиллуулах	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эцэг, эхийн хяналт, тусламжийн чанар дээшилнэ	ЭМГ	Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТ	2018-2021
<b>Үйл ажиллагааны чиглэл 2.3</b> Өсвөр үе залуучуудад үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.					
2.3.1	Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудыг давтан сургах	Өсвөр үе, залуучуудад үзүүлэх тусламжийн хүртээмж, чанар нэмэгдэнэ.	ЭМЯ ЭМГ	ЭМГ	2018-2019
2.3.2	Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч бэлтгэх	Үе тэнгийн сургагчаар дамжуулан залуучуудад мэдээлэл хүргэх нөхцөл бүрдэнэ.	ЭМГ Нэгдсэн эмнэлэг	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
2.3.3	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, үр нөлөөг сайжруулах чиглэлээр орон нутгийн түвшинд бодлого боловсруулагч, шийдвэр	Эрүүл мэндийн хичээлийн чанар, хүүхдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж, өвчнөөс урьдчилан сэргийлэх чадвартай болно	ЗДТГ, ЭМГ	БСУГ	2018-2021

	гаргагч нарт сурталчилгаа нөлөөлийн ажил зохион байгуулах				
2.3.4	Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн эмч нарыг бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалтанд хамруулж, мэдээлэл, сургалт сурталчилгааны материалаар хангах	Багш нар оюутан, сурагчдад нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг олгох чадвартай болно	ЭМГ	Флом байгууллага, Сургуулийн удирдлагууд	2018-2021
2.3.5	Сургууль засвардсан хүүхэд, ажилгүй залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулах	Залуучуудын эрүүл мэндийн боловсрол, мэдлэг дээшилж, өвчнөөс урьдчилан сэргийлнэ	ЭМГ Насан туршийн боловс-ролын төв	Төрийн болон ТББ	2018-2021

**Үйл ажиллагааны чиглэл 2.4** Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.4.1	Эмч эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд болон эмнэлэг хооронд шилжүүлэх, сэлгэн ажиллуулж, жирэмсэн эхчүүд, эх барих, нярай, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн яаралтай тусламжийн сургалтанд тогтмол хамруулж мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх	1.Ажлын байранд ялангуяа шинэ төгссөн эмч нарт зориулсан хүүхэд, нярай, жирэмсний хяналт болон эх барих, нярайн яаралтай тусламжийн чанар сайжирна.	ЭМГ	СӨЭМТ	2018-2021
2.4.3	Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед гарч болзошгүй эрсдэл, ургийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхийг нэмэгдүүлж, Эх барихын эмч нарыг эхо-н чиглэлээр сургах	Эх, хүүхдэд үзүүлэх тусламжийн чанар, хүртээмж нэмэгдэнэ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021

**Зорилт 3** Нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийг бууруулна.

**Зорилт 3-н үр дүн:**

Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж байгаа НҮНасны эмэгтэйчүүдийн эзлэх хувь 55 хүрнэ

<p>Үр хөндөлтийн түвшинг 150 промильд хүргэн бууруулна. Жирэмснээс сэргийлэх 5-с доошгүй эм хэрэгслээр үйлчилж байгаа ЭМТ-н тоог 50 хувьд хүргэнэ.</p>					
<p><b>Үйл ажиллагааны чиглэл 3.1</b> Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>					
3.1.1	Оюутан залуучууд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах	Залуучууд өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл төлөвлөлтөө зохицуулах чадвартай болно.	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ, БСГазар	2018-2021
3.1.2	Ерөнхий мэргэжлийн эмч, эх баригч болон эрүүл мэндийн бусад холбогдох мэргэжилтнийг гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр давтан сургах.	Эмч нарын мэдлэг ур чадвар дээшилж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ	ЭМГ, Нэгдсэн эмнэлэг	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
<p><b>Үйл ажиллагааны чиглэл 3.2</b> Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн тогтвортой хангамжийг бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>					
3.2.1	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл /бэлгэвч, дан болон хавсарсан эм дааврын эм, тариа, ерөндөг, суулгац, яаралтай ууж жирэмснээс сэргийлэх эм, бэлгийн замын халдварыг илрүүлэх хурдавчилсан оношлуур, үтрээний наацын шинжилгээний хэрэгсэл, төмрийн бэлдмэл, фолийн хүчил /-ээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг хангах	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын хангалт нэмэгдэж, иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмж дээшилнэ.	ЭМГ, ЗДТГ	ЭМЯ, ОУБ, ТББ	2018-2021
<p><b>Үйл ажиллагааны чиглэл 3.3</b> Үр хөндөлтийн өмнөх, дараах цогц тусламж, үйлчилгээг бэхжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>					
3.3.1	Эмэгтэйчүүдэд хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн хор уршиг, гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах сургалт сурталчилгаа хийх	Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, жирэмжлэлтээ зөв төлөвлөх чадвартай болно.	ЭМГ	Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл	2018-2021
3.3.2	Аюултай үр хөндөлтөөс сэргийлэх арга	Үр хөндөлтийн тоо буурна	МХГ,		

	хэмжээг зохион байгуулах		Цагдаагийн газар	ЭМГ	2018-2021
<p><b>Зорилт 4</b> Хүн амд жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн боловсрол олгон эрүүл зан үйлийг төлөвшүүлэн эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад гэр бүлийн гишүүд иргэдийн оролцоо үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.</p> <p><b>Зорилт 4-н үр дүн:</b>  Охидын төрөлтийн түвшинг нийт төрөлтийн 4 хувьд хүргэн бууруулна.  Осол гэмтлээс шалтгаалсан хүүхдийн эндэгдлийг 18 хувьд хүргэж бууруулна.  Хөхний сүүгээр 6 сар хүртэл дагнан хоолох хувийг 70 хувьд хүргээ нэмэгдүүлнэ.</p>					
<p><b>Үйл ажиллагааны чиглэл 4.1</b> Зорилтот бүлгийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>					
4.1.1	Хүн амд эх, хүүхэд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, мэдлэг олгох ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
4.1.2	Өрх сумын эрүүл мэндийн төвд хүүхдийн асаргаа, сувилгаа, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө өгөх эрүүл мэндийн нийгмийн ажилтан, сайн дурын ажилтнуудыг бэлтгэх	Харьяа нутаг дэвсгэрийн хүн амд хүргэх мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
4.1.3	Зорилтот бүлэгт чиглэсэн гэр бүл төлөвлөлт, эсэн мэнд амаржихуй, эмийн зохистой хэрэглээ, хүүхдийн асаргаа сувилгаа, хатгалгаа, суулгалт, хүүхдийн сэтгэцийн тулгамдсан асуудал, үр хөндөлт, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх сургалт суртчилгааны ажлыг зохион байгуулах	Иргэдийн мэдлэг нэмэгдэж аливаа өвчнөөс өөрийгээ болон гэр бүлийн гишүүдээ урьдчилан сэргийлнэ	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ	2018-2021
4.1.4	Цэвэршилтийн насны хүн амд нөхөн үржихүйн дараахь тусламж үйлчилгээний талаар мэдээлэл сургалт явуулах, зөвлөгөө өгөх	Зорилтот насны иргэдийн эрүүл мэнд сайжирна	ЭМГ	ЗДТГ, СӨЭМТ хороо,	2018-2021
4.1.5	Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Эх, хүүхдийн эрүүл	Иргэд мэдээлэл шуурхай хүрнэ			

	мэндийн нэвтрүүлгийн цаг, булан ажиллуулж, аливаа эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, тусламж хайх чиглэлээр иргэдэд зориулсан сургалт суртчилгааг тогтмол зохион байгуулах		ЭМГ	Хэвлэл мэдээлэлийн байгууллага	2018-2021
4.1.7	"Эх, хүүхэд ээлтэй Эрүүл мэндийн дэмжигч байгууллага, аж ахуйн нэгж, ерөнхий боловсролын сургууль шалгаруулж, дүгнэх, сурталчлах	Байгууллага бүр эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж хэвшинэ	ЭМГ	Байгууллага, сургуулийн удирдлагууд	2018-2021
<p><b>Зорилт 5</b> Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, тандалт, судалгаа хяналт шинжилгээ үнэлгээг сайжруулна.</p> <p><b>Зорилт 5-н үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Тав хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажгийг батлагдсан маягтаар цахим хэлбэрээр мэдээлж байгаа эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувийг 100% -д хүргэнэ</li> <li>Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж орон нутгийн бүх эрүүл мэндийн байгууллагуудад 100 хувь хэрэгжинэ.</li> </ul> <p><b>Үйл ажиллагааны чиглэл 5.1</b> Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл, судалгааны үр дүнгийн хэрэглээг сайжруулж нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл явцыг дэмжих нөхцөл бүрдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>					
5.1.1	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эх баригч нарыг тархвар зүйн сургалтанд хамруулах	Эмчилгээ, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	ЭМГ	Сум, өрхийн эрүүл мэндийн төв	2018-2021
5.1.2	Эх нярайн теле оношлогоо, мэдээлэл, цахим сургалтын бааз бүрдүүлэн ашиглаж хэвших	Эх нярайн теле шуурхай оношлогоо хамтын ажиллагаа дээшилнэ	ЭМГ	Нэгдсэн эмнэлгийн НҮЭМК	2018-2021